



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/587

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчөөс төрийн өмчид  
эд хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дах заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 55 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Энэ захирамжийн хавсралтад заасан нийт 257,799,960.00 (хоёр зуун тавин долоон сая долоон зуун ерэн есөн мянга есөн зуун жар) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий үлдэх өртөггүй 2 тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсүгэй.

2.Хавсралтад заасан нийт 257,799,960.00 (хоёр зуун тавин долоон сая долоон зуун ерэн есөн мянга есөн зуун жар) төгрөгийн бүртгэлийн үнэ үлдэх өртөггүй 2 тээврийн хэрэгслийг төрийн өмчид шилжүүлэх ажлыг зохион байгуулж, данс бүртгэлээсээ хасахыг “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ (О.Ганбаатар)-т үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110202832

Нийслэлийн Засаг даргын 2024 оны  
05 дугаар сарын 21 өдрийн  
1587 дугаар захирамжийн  
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Тээврийн хэрэгсэл	Hyundai County	22-96 УБН	KMJHL7PPEC 067317	2015	128,899,980.00	128,899,980.00	-	"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ	Шүүх шинжилгээний газар
2	Тээврийн хэрэгсэл	Hyundai County	80-52 УБН	KMJHL7PPEC 067328	2015	128,899,980.00	128,899,980.00	-		
Нийт дүн						257,799,960.00	257,799,960.00	-		